



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 9/17

Мандалговь

Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул
орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах,
тэмдэг, тэмдэглэгээ байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Дундговь аймгийн Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг, тэмдэглэгээ байгуулах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Э.Энхжаргал (Орон нутгийн өмчийн газрын
худалдан авах ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:
 Ю.Отгондэлгэр (Иргэний төлөөлөл)
 Х.Мөнхсаруул (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын хүний нөөц хариуцсан
ахлах мэргэжилтэн)
 М.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын үйлчилгээний албаны
дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын
газрын мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Энхжаргал)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Батхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.Доржбат Л.ДОРЖБАТ

488210500